



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/02

Улаанбаатар хот

**2026 оны Хөрөнгө оруулалтын ажлыг  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 48 дугаар зүйлийн 48.1, Төсвийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны A/23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 онд Нийслэлээс эрх шилжиж ирсэн ажил болон дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн шуурхай, үр дүнтэй зохион байгуулахыг Худалдан авах ажиллагааны алба (О.Содовжамц)-нд даалгасугай.

2.Тендерт шалгарсан байгууллагатай гэрээ байгуулах, гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд холбогдох байгууллагуудтай хамтран захиалагчийн хяналт тавих, гэрээт ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авах, өмч хөрөнгийг бүртгэн авах, ашиглалт хамгаалалтыг эзэмшигч байгууллагад хариуцуулан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3.Хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Мягмарсүрэн)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД